



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А170

Улаанбаатар хот

Шилдэг судлаач шалгаруулах тухай

Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.2-т “Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх” болон хуулийн 8.1.14-т “Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж урамшуулах” тухай тус тус заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. “Оны шилдэг судлаач”, “Оны шилдэг бүтээл” шалгаруулах журмыг нэгдүгээр, бүтээл шалгаруулж дүгнэлт гаргах “Эрдэмтдийн шинжээчийн багийн нэрс”-ийг хоёрдугаар, “Бүтээлд тавигдах шаардлага”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. “Оны шилдэг судлаач”, “Оны шилдэг бүтээл” шалгаруулах уралдааны материалыг жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны дотор хүлээн авч, нэгтгэхийг эрдэм шинжилгээний ажилтан Е.Гүлжанат, Т.Мандхай нарт үүрэг болгосугай.

3. Уралдааны өргөмжлөл, мөнгөн шагналыг тооцож олгохыг санхүү бүртгэлийн албаны дарга /н.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Уралдаанд ирсэн бүтээлийн материалыг архив, бичиг хэргийн ажилтан /С.Тунгалагтамир/-д хадгалуулсугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг НЭМЭШСГХ дэд захирал /В.Баярмаа/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Л.НАСАНЦЭНГЭЛ



000503